



БАНКНЫ САЛБАРЫН ТОЙМ

2025 оны эхний хагас жилийн тайлан

ЗУНЫ САР ЗУРГАА БИШ ДЭЭ

Зуны сар зургаа биш дэ.

Банкны салбарын үзүүлэлт харьцангуй тогтвортой, өсөлттэй, нийт актив өмнөх оны мөн үетэй харьцуулахад 30 хувиар нэмэгдлээ. Иргэд цалин, тэтгэвэр болон хадгаламж барьцаалсан зээл түлхүү авчээ. Эдийн засгийн салбаруудын сэргэлтэд банкны олгож буй зээл чухал нөлөөтэй байна. Тухайлбал, бизнесийн зээл тэр дундаа боловсруулах, барилга болон худалдаа, үйлчилгээний салбарт олгосон зээлийн хэмжээ огцом нэмэгджээ. Инфляцын өсөлт удааширч, төгрөгийн ханш чангарсны улмаас төгрөгийн хадгаламжийн өгөөж нэмэгджээ.

Эхний хагас жилд эдийн засгийн өсөлт 5.6 хувьтай гарсан. Оны эхнээс уул уурхайн салбар, түүнийг дагаад тээвэр, агуулахын салбарын өсөлт харьцангуй хурдан байсан нь эдийн засгийн өсөлтөд чухал нөлөөтэй байна. Барилга, боловсруулах салбар сэргэж эхэлсэн нь эдийн засгийн өсөлтөд эергээр нөлөөллөө. Цаг уурын нөхцөл байдлаас шалтгаалан ХАА-н салбар уналттай байна. Манай улсын валютын нөөц өнгөрсөн онтой харьцуулахад 26 хувиар өссөн хэдий ч импортын бараа, бүтээгдэхүүний өсөлт өндөр байна. Ийм түвшинд төгрөгийн бодит ханш чангарч байгаа нь Монгол Улсын өрсөлдөх чадварыг бууруулж байна.

Зуны цаг зургаа биш гэдгийг санаж эдийн засгийн өсөлтийг тогтвортой хадгалахад чиглэсэн бодлого баримталж, төсвийн зарлагыг тодорхой хэмжээнд хязгаарлаж, гол экспортын бараа, бүтээгдэхүүний үнэ болон тоо хэмжээний бууралтад эртнээс бэлдэхэд анхаарах шаардлагатай байна.



Иргэдэд олгох хэрэглээний зээл буурч байна.

Хадгаламж барьцаалсан зээл 26 хувиар нэмэгджээ. Малчдад олгосон зээл 40 хувиар нэмэгджээ.
Харин цалин, тэтгэврийн зээл 30 хувиар буурчээ.

Онцлох өөрчлөлт,
энгийн тайлбар

Иргэдийн зээл олголт, жил бүрийн II улирал



Онолын тодорхойлолт

Банкны шинээр олгосон зээл

Жич: Тухайн жилд банкны шинээр гаргасан зээлийн хэмжээгээр зээлийн үлдэгдэл нэмэгддэг.

Шинээр иргэдэд олгосон зээлийн хэмжээ нэмэгдэв.

-4%

2024 оны II
улирлын гүйцэтгэл

2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛД БАНКНЫ САЛБАРЫН ОНЦЛОХ ӨӨРЧЛӨЛТ, ЦААШДЫН ХАНДЛАГА



Банкуудын бизнесийг дэмжихэд чиглэсэн зээлийн өсөлт үргэлжилсээр байна.



Банкуудын чанаргүй зээлийн хэмжээ буурчээ.



Төгрөгийн хадгаламжийн өгөөж нэмэгдсэн нь төгрөгийн хадгаламж нэмэгдэхэд чухал нөлөө үзүүлээ.



Системийн нөлөө бүхий 5 банкны санхүүгийн үзүүлэлт харьцангуй сайн байна.



Банкнүүдын хувьцааны ханш тогтвортой байна.



Банкнүүдын хувьцааны өгөөж хадгаламжийн өгөөжөөс өндөр байна.

БАНКУУДЫН САНХҮҮГИЙН ГОЛЛОХ ҮЗҮҮЛЭЛТ

2025 оны эхний хагас жилийн гүйцэтгэл

Эдийн засгийн өсөлтийг дэмжихэд чиглэсэн банкны салбарын зээлийн өсөлт үргэлжилсээр байна.


Эдийн засгийн салбаруудын өсөлтийг дэмжихэд чиглэсэн бизнесийн зээл олголт нэмэгджээ. Иргэдийн хэрэглээний зээл буурч эхэлжээ.

Банкны зээлийн багц

Жич: Зээлийн үлдэгдэл нь шинээр олгосон зээлээр нэмэгдэж, эргэн төлөлтөөр буурч байдаг.

+27%

Зээлийн үлдэгдэл өсөв.




Эдийн засгийн салбаруудыг дэмжсэн бизнесийн зээлийн өсөлт үргэлжилсээр байна.

Уул уурхай, боловсруулах, барилга болон худалдааны салбарыг дэмжсэн зээл олголт өндөр байна.
Үйлчилгээний салбарт олгох зээл олголт буурчээ.

Тэрбум ₮

Бизнесийн зээл олголт, жил бүрийн II улирал



Банкны шинээр олгосон зээл

Жич: Тухайн жилд банкны шинээр гаргасан зээлийн хэмжээгээр зээлийн үлдэгдэл нэмэгддэг.

Шинээр бизнесүүдэд
олгосон зээл

19%

нэмэгджээ.

Банкны зээлийн чанар

Жич: 90 хоногоос дээш хугацаагаар зээлээ төлөөгүй нөхцөлд чанаргүй зээлд шилждэг.

Салбарын хэмжээнд
чанаргүй зээлийн хэмжээ

5%


Эх сурвалж: Монголбанк
Үндэсний статистикийн хороо

Банкны салбарын чанаргүй зээлийн хэмжээ буурчээ.


Цалин, тэтгэврийн зээл болон автомашины зээлийн чанаргүйдэл нэмэгджээ.

Эдийн засгийн салбарууд харьцангуй өсөлттэй байгаа нь бизнесийн зээлийн чанаргүйдэл буурахад нөлөөлж байна.

Иргэдийн чанаргүй зээлийн харьцаа, жил бүрийн II улирал



Бизнесийн чанаргүй зээлийн харьцаа, жил бүрийн II улирал




Эх үүсвэр хугацаагүй хадгаламжаас хугацаатай хадгаламж руу шилжиж байна.

Төгрөгийн ханш суларч буй хэдий ч иргэдийн төгрөгт итгэх өндөр байгаа нь нөлөөлж төгрөгийн хадгаламж 15%-аар нэмэгджээ. .
Валютын хугацаагүй хадгаламжаас хугацаатай хадгаламж руу шилжиж байна. .

Банкны эх үүсвэр, жил бүрийн II улирал

Их наяд ₮



Банкны эх үүсвэр

Жич: Энэ нь банкны татан төвлөрүүлсэн харилцах, хадгаламжийг хэлдэг.

Төгрөгийн хадгаламж

15%

НЭМЭГДЖЭЭ.

Банкны жигнэсэн дундаж хүү

Жич: Банкуудын шинээр татсан эх үүсвэрийн хүү, олгосон зээлийн хүү нь цаг хугацаа, мөнгөн дүнгийн хувьд жинлэгдсэн дундаж хүүг хэлнэ.

Зээлийн хүү


17%

Эх сурвалж: Монголбанк

Хүү тогтвортой байна.

Гадаад, дотоод эдийн засгийн нөхцөл байдлаас шалтгаалан бодлогын хүүг өсгөсөн хэдий ч хүүгийн түвшин харьцангуй тогтвортой байна.

Эдийн засаг тогтворжиж буй нь зээлийн хүү аажмаар буурах хүлээлтийг үүсгэлээ.



БАНКУУДЫН САНХҮҮГИЙН ГОЛЛОХ ҮЗҮҮЛЭЛТ

2025 оны эхний хагас жилийн гүйцэтгэл

Банкны актив буюу хөрөнгө

Жич: Банкны нийт өр төлбөр дээр нэмэх нь эздийн өмчийг бүхэлд нь банкны хөрөнгө буюу актив гэнэ.

Системийн нөлөө бүхий
банкуудын актив


30%

ӨСӨВ.

Банкны системийн нийт актив өмнөх оны мөн үеэс 13 их наяд төгрөгөөр нэмэгджээ.

Төрийн банкны актив 37 хувиар, Голомт банкны актив 34 хувиар, Хас банкны актив 32 хувиар тус тус өсжээ. ХХБ-ны актив 29 хувиар, Хаан банкны актив 26 хувиар тус тус нэмэгджээ.


Банкуудын актив, жил бүрийн II улирлаар харуулав.



Банкны салбарын нийт эх үүсвэр өмнөх оны мөн үетэй харьцуулахад 8.4 их наяд төгрөгөөр нэмэгджээ.

Төрийн банкны эх үүсвэр 38 хувиар, ХХБ-ны эх үүсвэр 33 хувиар тус тус нэмэгджээ.

Банкуудын эх үүсвэр, жил бүрийн II улирал



Банкны эх үүсвэр

Жич: Иргэд, байгууллага болон хөрөнгө оруулагчдаас татсан өр төлбөрийн хэмжээ.

Банкуудын эх үүсвэр

29%

НЭМЭГДЭВ.

Өөрийн хөрөнгийн өгөөж

Жич: Тухайн байгууллага нь өөрийн хөрөнгөө хэр үр ашигтай зарцуулж буй тухай мэдээлэл өгдөг. Өөрөөр хэлбэл компани хөрөнгийг хэрхэн ашиг болгож буйг илэрхийлдэг үзүүлэлт юм.

Банкуудын өөрийн
хөрөнгийн өгөөж


14%

Эх сурвалж: Банкуудын
аудитлагдаагүй тайлан

Банкнудын өөрийн хөрөнгийн өгөөж хадгаламжийн өгөөжөөс өндөр байна.

Системийн нөлөө бүхий банкуудын өөрийн хөрөнгийн дүн 5.9 их наяд төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 19 хувиар өсжээ.

Банкуудын өөрийн хөрөнгийн өгөөж, жил бүрийн II улирал




Банкуудын өөрийн хөрөнгийн хүрэлцээ буурч буй хэдий ч хангалттай хэмжээний зээл гаргах хөрөнгөтэй байна.

Эдийн засгийг дэмжих, гол салбаруудын сэргэлтийг хурдасгахад чиглэсэн зээлийн өсөлт нь банкуудын өөрийн хөрөнгийн хүрэлцээг буурахад нөлөөлжээ.

Иргэдийн хэрэглээний зээлийн өсөлт үргэлжилсээр байна.

Банкуудын өөрийн хөрөнгийн хүрэлцээ, жил бүрийн II улирал



2022	2023	2024
Хаан		
2022	2023	2024
ХХБ		
2022	2023	2024
Голомт		
2022	2023	2024
Төрийн банк		
2022	2023	2024
Хас		

Өөрийн хөрөнгийн хүрэлцээ

Жич: Санхүүгийн болон үйл ажиллагааны эрсдэлээс гарах алдагдлыг хаахад хүрэлцэхүйц хэмжээний өөрийн хөрөнгөтэй эсэхийг тодорхойлсон үнэлгээг хэлдэг

Банкуудын өөрийн хөрөнгийн хүрэлцээний дундаж

16%

Хөрвөх чадварын харьцаа

Жич: Богино хугацаат төлбөрүүдийг цаг тухайд нь төлөх чадварыг хэмждэг харьцаа.

Системийн нөлөө бүхий банкуудын хөрвөх чадварын харьцаа үзүүлэлтийн дундаж


40%

Эх сурвалж: Банкуудын аудитлагдаагүй тайлан

Системийн нөлөө бүхий 5 банкны хөрвөх чадварын харьцаа үзүүлэлт хэт өндөр хэвээр байна.

Банкуудын хөрвөх чадварын харьцаа үзүүлэлт нэмэгджээ.

Банкуудын хөрвөх чадварын харьцаа, жил бүрийн II улирал



2022	2023	2024
Хаан		
2022	2023	2024
ХХБ		
2022	2023	2024
Голомт		
2022	2023	2024
Төрийн банк		
2022	2023	2024
Хас		


МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ОРЧИН

2024 оны эхний хагас жил: Эдийн засгийн өсөлт 5.6 хувьтай гарлаа. Уул уурхайн салбар, түүнийг дагаад тээвэр, агуулахын салбарын өсөлт харьцангуй хурдан байсан нь эдийн засгийн өсөлтөд эерэг нөлөө үзүүлжээ. Боловсруулах болон эрчим хүчний салбар сэргэж байна. Цаг уурын нөхцөл байдлаас шалтгаалан ХАА-н салбар уналттай байна. Эрэлтийн талаас нь харвал хэрэглээ болон хөрөнгө оруулалтын хэмжээ нэмэгдсэн нь эдийн засгийн сэргэлтийг нэмэгдүүлсэн бол импортын хэмжээ нэмэгдэж буй нь өсөлтөд сөрөг нөлөө үзүүлжээ. Нийлүүлэлтийн гаралтай инфляцын түвшин буурч байна.

Төлөв байдал: Хэрэв цаашид Оюу толгойн гүний уурхайн олборлолт, түүхий эдийн бүтээгдэхүүний экспортын урсгал хэвийн явагдвал эдийн засгийн өсөлт үргэлжлэх хүлээлтийг буй болгож байна. БНХАУ-ын эдийн засагт гарч буй өөрчлөлт нь манай улсын эдийн засгийн нөхцөл байдалд сөргөөр нөлөөлөх төлөвтэй. Нийлүүлэлтээс үүдэлтэй инфляцын өсөлтийн хурд саарч байна.

2024 оны эхний хагас жилд эдийн засаг 5.6 хувиар өсөв.

Уул уурхайн салбарын өсөлт түүнийг дагасан тээвэр, агуулах болон үйлчилгээний салбар эрчимжиж эхэлсэн нь эдийн засгийн өсөлтийн дийлэнх хувийг бүрдүүлэв. Боловсруулах болон барилгын салбар сэргэж эхэлсэн нь эдийн засгийн өсөлтөд чухал нөлөө үзүүллээ. Цаг уурын нөхцөл байдлаас шалтгаалан ХАА-н салбар уналттай байгаа нь эдийн засгийн өсөлтөд сөргөөр нөлөөлөө.




Гадаад худалдааны тэнцэл 23.5 хувиар буурчээ.

Нүүрс болон төмрийн хүдрийн тоо хэмжээ өсөлттэй буй ч дэлхийн зах зээл дээрх үнэ буурсан нь экспортын хэмжээ буурахад нөлөө үзүүлээ. Импортын бараа бүтээгдэхүүн тэр дундаа суудлын авто машин болон хөрөнгө оруулалтын зориулалттай импортын бараа, бүтээгдэхүүний эрэлт өссөн нь импорт нэмэгдэхэд чухал нөлөө үзүүлээ.


Уул уурхайн гол бүтээгдэхүүний дэлхийн зах зээл дэх үнэ буурсан нь **экспортын өсөлтөд** нөлөөллөө.

Хувиар




Хөрөнгө оруулалтын зориулалттай бараа бүтээгдэхүүний **импорт нэмэгджээ.**

Хувиар



Импортын өсөлт нь **худалдааны тэнцлийн ашиг буурахад** нөлөөллөө.

Тэрбум,доллар




Төгрөгийн бодит ханш аажмар чангарч манай улсын бараа бүтээгдэхүүн бусад улстай харьцуулахад үнэтэй болж байна.

Төлбөрийн тэнцэл 57.3 сая ам.долларын алдагдалтай гарлаа.


Иргэд болон засгийн газрын хэрэглээ нэмэгдсэн нь импортын бараа, бүтээгдэхүүний эрэлтийг нэмэгдүүлж урсгал данс алдагдалтай гарахад нөлөөллөө.

Өмнөх оны мөн үетэй харьцуулахад гадаадын шууд хөрөнгө оруулалт 50 орчим хувиар нэмэгдсэнээр санхүүгийн данс ашигтай гарчээ.

Төгрөгийн нэрлэсэн болон бодит үйлчилж буй ханш



Төлбөрийн тэнцэл




Валютын нөөц нэмэгдсэн хэдий ч импортын өсөлт өндөр байна.

Валютын нөөц өмнөх оны мөн үетэй харьцуулахад 26 хувь өссөн байна.


Бараа бүтээгдэхүүний дэлхийн зах зээлийн үнэ аажмаар тогтворжиж байгаа нь нийлүүлэлтийн гаралтай үнийн түвшний өсөлтийн хурдыг саарахад нөлөөлж байна.

Инфляц аажмаар буурч төгрөгийн хадгаламжийн өгөөж нэмэгдлээ.

Импортын 5 сарын хэрэглээг хангах валютын нөөцтэй байна



Инфляцын түвшин аажмаар буурч төгрөгийн хадгаламжийн өгөөж нэмэгдэж эхэллээ.



Төсвийн тэнцэл 1.3 их наяд төгрөгийн ашигтай гарч төсвийн алдагдлын дарамт буурч байна.


Оюу толгойн гүний уурхайн олборлолт болон уул уурхайн гаралтай бүтээгдэхүүний экспортын өсөлтөөс үүдэлтэй татварын орлого нэмэгдсэн нь төсвийн орлогыг нэмэгдүүлжээ.

Урсгал зардлын өсөлт нь төсвийн зарлагын дийлэнх хувийг эзэлжээ.

Үндсэн тэнцэл ашигтай гарч төсвийн алдагдлын дарамт буурах төлөвтэй байна.


Төсвийн орлого өмнөх оны мөн үеэс 35 хувиар өсжээ.

ДНБ-д эзлэх хувиар




Нийт төсвийн зарлага 43 хувиар нэмэгджээ.

ДНБ-д эзлэх хувиар



Төсвийн тэнцэл ашигтай байна

ДНБ-д эзлэх хувиар



ЗАСГИЙН ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРТ ХҮРГҮҮЛЭХ САНАЛ



Намуудын мөрийн хөтөлбөр 2024-2028:

	1. Зээлийн хүүг бууруулах	2. Санхүүгийн салбарын хууль эрхзүйн орчныг сайжруулах	3. Салбарын бүтээгдэхүүн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх	4. Тогтвортой ногоон санхүүжилтийг бодлогоор дэмжих
МАН	✓	✓		✓
АН	✓	✓	✓	✓
ХҮН	✓	✓	✓	✓
ЗГҮАХ		✓	✓	✓

1. ЗЭЭЛИЙН ЭРСДЭЛ, ЗАРДЛЫГ БУУРУУЛАХ

1. Шүүхийн болон шүүхийн бус журмаар чанаргүй зээлийг шуурхай шийдвэрлэх, өмчлөгч болон үнэлгээний эрх зүйн орчныг сайжруулах

Зээл шүүх рүү шилжсэн тохиолдолд хүү зогсдог байдлыг болиулах (Багц хуулийн шинэчлэл)
Чанаргүй зээл төлөгдөх хугацаа жил бүр хэмжиж, бууруулах

2. Актив удирдлагын компани байгуулах

Суурь судалгаануудыг хийх
Актив удирдлагын компанийн тухай хууль батлуулах
Актив удирдлагын компани байгуулах

Багц хуулиуд: Иргэний хууль, Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо, зээлийн үйл ажиллагааны тухай хууль, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд тус тус өөрчлөлт оруулах хуулийн төслийг боловсруулж, өргөн мэдүүлэх

2. ГАДААДЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ОРЧНЫГ САЙЖРУУЛАХ, НЭМЭГДҮҮЛЭХ

1. Банкны тухай хуульд өөрчлөлт оруулах

“Аливаа этгээд дангаар болон холбогдох этгээдийн хамт эзэмших банкны хувьцаа, хувьцаанд хамаарах үнэт цаасны хэмжээ тухайн банкны нийт гаргасан хувьцааны 20 хувиас хэтрэхгүй байх” гэснийг 40 хүртэл хувь болгож нэмэгдүүлэх

2. Зохицуулагч байгууллагын хяналт, шалгалтын давхардлыг арилгах

Давхардсан 30 орчим журам байна

3. БАНКНЫ САЛБАРЫН БҮТЭЭГДЭХҮҮН, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХҮРТЭЭМЖИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ

1. Банк болон зээлдэгчийн эрсдэл хуваалцах санхүүгийн байгууллагуудын оролцоог нэмэгдүүлэх

“Зээлийн батлан даалтын сангийн ашиглалтыг нэмэгдүүлэх, тоон зорилт тавих

ЗГ-ын дэмжлэгтэй төсөл хөтөлбөрүүдийн зээлийг даатгах, даатгалын зардлыг ЗГ/зээлдэгч/банк хуваалцах

2. Бизнесийн онцлогт тохирсон санхүүгийн бүтээгдэхүүнийг нэмэх

Санхүүгийн түрээс, нэмүү өртгийн сүлжээний санхүүжилт, хөдлөх хөрөнгө барьцаалсан зээл гэх мэт Шүүхтэй холбоотой хугацаа, зардлыг бууруулах

4. ТОГТВОРТОЙ, НОГООН САНХҮҮЖИЛТИЙГ БОДЛОГООР ДЭМЖИХ

1. Ногоон зээлийн хөшүүрэг, дэмжлэгийн тогтолцоог сайжруулах

Эрсдэлийн хувь хэмжээний хөшүүрэг

Татаасыг зарлах

Иргэдийн ногоон зээлд тавигдах хугацааны шалгуурыг уртасгах

2. Ногоон зээлийн тодорхойлолт, шалгуур үзүүлэлтүүдийг хэмждэг хянадаг тайлагнадаг тогтолцоог (MRV system) нэвтрүүлэх

Уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой дата мэдээллийг ил тод болгох

Ногоон зээл санхүүжилттэй холбоотой үндэсний дата санг бий болгох

3. Салбарын ажиллагсдын тогтвортой санхүүжилтийн мэдлэгийг сайжруулах